

УВС ФИНАНС АУДИТ ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сагил сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/98/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаангом хот
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн "Увс Финанс аудит" ХХК
аудитор: Я.Тунгалаг
Утас: 99458717 Цахим хаяг:ynarantuya310@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



САГИЛ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Ж.ОТГОНЖАРГАЛ ТАНАА

**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2023.02.18 № УВА-2023/98/НА-СГА-ТЦУЗ
танай -ны № -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сагил сумын Цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сагил сумын Цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Боловсрол шинжлэх ухааны яамны хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэрээс 17,082.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 3,652.6 мянган төгрөгийн бараа материал нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

0200000430


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
Дүгнэлтийн үндэслэл.....	3
Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно...	3
Асуудлыг онцолсон хэсэг	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5.1 Завсрын аудитын талаар	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шүүд захирагч
НА	Нийцлийн аудит

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>28,338,224.0</u>	<u>42,691,807.7</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.0	13,328,372.7
312	Банканд байгаа бэлэн мөнгө	0.0	13,328,372.7
3121	Төгрөг	0.0	13,328,372.7
31211	Төрийн сангийн харилцах	0.0	13,328,372.7
33	АВЛАГА	14,000,000.0	0.0
335	Бусад авлага	14,000,000.0	0.0
3351	Байгууллагаас авах авлага	14,000,000.0	0.0
35	БАРАА МАТЕРИАЛ	14,338,224.0	29,363,435.0
354	Хангамжийн материал	14,338,224.0	29,363,435.0
35410	Бичиг хэргийн материал	933,300.0	952,800.0
35420	Аж ахуйн материал	13,029,400.0	27,445,085.0
35460	Хүнсний материал	375,524.0	965,550.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>502,599,831.8</u>	<u>495,628,431.3</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	502,599,831.8	495,628,431.3
392	Биет хөрөнгө	492,647,631.8	485,736,231.3
39201	Барилга, байгууламж, орон сууц	459,820,387.5	459,820,387.5
39202	Хуримтлагдсан элэгдэл	-21,359,526.6	-32,229,525.6
39205	Машин тоног төхөөрөмж	35,488,980.0	40,218,980.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	-24,150,038.6	-27,290,590.3
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	60,192,928.4	69,785,776.4
39208	Хуримтлагдсан элэгдэл	-38,328,391.7	-45,633,844.9
39214	Бусад үндсэн хөрөнгө	26,235,602.0	28,995,282.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	-8,369,849.3	-11,047,773.8
39217	Ном	3,117,540.0	3,117,540.0
393	Биет бус хөрөнгө	9,952,200.0	9,892,200.0
39301	Программ хангамж	300,000.0	300,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-105,000.0	-165,000.0
39303	Бусад биет бус хөрөнгө	9,757,200.0	9,757,200.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>530,938,055.8</u>	<u>538,320,239.1</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>84,150.8</u>	<u>0.0</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	84,150.8	0.0
413	Өглөг	84,150.8	0.0
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	84,150.8	0.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>530,853,904.9</u>	<u>538,320,239.1</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	530,853,904.9	538,320,239.1
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	54,119,147.0	54,119,147.0
51101	Өмч: - төрийн	54,119,147.0	54,119,147.0
512	Хуримтлагдсан үр дүн	476,734,757.9	484,201,092.0
51210	Өмнөх үеийн үр дүн	476,734,757.9	476,734,757.9
51220	Тайлант үеийн үр дүн	0.0	7,466,334.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>530,938,055.8</u>	<u>538,320,239.1</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	319,497,100.00	342,702,213.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,799,800.00	15,735,213.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,799,800.00	15,735,213.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө	4,799,800.00	12,082,528.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Бараа материал		3,652,685.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	25,796,400.00	326,967,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	284,268,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	284,268,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	288,900,900.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	680,000.00	00.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	500,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	180,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	25,116,400.00	42,698,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	25,116,400.00	42,698,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	323,228,541.01	335,235,878.88
21	УРСГАЛ ЗАРДАЛ	323,228,541.01	335,235,878.88
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	297,534,998.48	334,038,861.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	208,450,375.82	220,505,483.00
210101	Үндсэн цалин	159,250,544.82	156,459,188.00
210102	Нэмэгдэл	26,082,278.00	52,575,303.00
210104	Урамшуулал	18,157,735.00	9,622,992.00
210105	Гэрээт ажлын хөлс	4,959,818.00	1,848,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,320,157.45	26,264,724.98
210201	Тэтгэврийн даатгал	18,524,625.17	19,225,657.57
210202	Тэтгэмжийн даатгал	2,022,558.58	2,023,359.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,617,906.86	1,764,319.24
210204	Ажилгүйдлийн даатгал	359,168.54	295,580.74
210205	Эрүүл мэндийн даатгал	3,795,898.30	2,955,807.64
2103	Байр ашиглалттай хөлбөөтэй тогтмол зардал	22,205,665.00	23,617,962.00
210301	Гэрэл, цахилгаан	1,289,221.00	2,401,518.00
210302	Түлш, халаалт	20,916,464.00	21,216,464.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,565,350.00	3,373,468.00
210401	Бичиг хэрэг	122,000.00	26,400.00
210402	Тээвэр, шатахуун	1,646,350.00	1,827,925.00
210403	Шуудан, хөлбөө, интернэтийн төлбөр	00.00	140,143.00
210404	Ном, хэвлэл	33,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,264,500.00	115,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	499,500.00	1,258,000.00
2105	Норматив зардал	8,737,766.00	30,375,725.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	65,000.00	00.00
210502	Хоол, хүнс	8,672,766.00	30,375,725.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,390,000.00	690,000.00
210604	Урсгал засвар	2,390,000.00	690,000.00
2107	Томилолт, зочны зардал	42,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	42,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	420,000.00	678,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	288,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	132,000.00	390,000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,403,664.19	28,533,478.41
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	1,480,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,991,100.00	2,999,550.00
210903	үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,412,564.19	24,053,928.41
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,693,542.55	1,197,017.49
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,193,542.55	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,193,542.55	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	1,197,017.49
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,197,017.49
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-3,731,441.01	7,466,334.12
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	133,134.64	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	133,134.64	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-133,134.64	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-3,864,575.65	7,466,334.12

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	314,697,300.00	326,967,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	314,697,300.00	326,967,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	284,268,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	284,268,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	288,900,900.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	680,000.00	00.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	500,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	180,000.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	25,116,400.00	42,698,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	25,116,400.00	42,698,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	314,697,300.00	313,638,627.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	314,697,300.00	313,638,627.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	289,003,757.45	312,441,609.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	208,366,225.00	220,589,633.82
210101	Үндсэн цалин	159,166,394.00	156,543,338.82
210102	Нэмэгдэл	26,082,278.00	52,575,303.00
210104	Урамшуулал	18,157,735.00	9,622,992.00
210105	Гэрээт ажлын хөлс	4,959,818.00	1,848,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,320,157.45	26,264,724.98
210201	Тэтгэврийн даатгал	18,524,625.17	18,745,891.92
210202	Тэтгэмжийн даатгал	2,022,558.58	2,205,399.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,617,906.86	1,764,319.24
210204	Ажилгүйдлийн даатгал	359,168.54	322,646.78
210205	Эрүүл мэндийн даатгал	3,795,898.30	3,226,468.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,205,685.00	23,617,982.00
210301	Гэрэл, цахилгаан	1,289,221.00	2,401,518.00
210302	Түлш, халаалт	20,916,464.00	21,216,464.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,681,150.00	00.00
210401	Бичиг хэрэг	245,300.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	1,476,350.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	70,000.00	00.00
210404	Ном, хэвлэл	193,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,197,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,499,500.00	00.00
2105	Нормативт зардал	9,520,290.00	30,965,751.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	65,000.00	00.00
210502	Хоол, хүнс	9,039,290.00	30,965,751.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	416,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,090,000.00	800,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	500,000.00	00.00
210604	Урсгал засвар	1,590,000.00	800,000.00
2107	Томилот, зочны зардал	42,000.00	00.00
210702	Дотоод албан томилот	42,000.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	420,000.00	486,466.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	132,000.00	486,466.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,358,250.00	9,717,052.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	6,717,502.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,358,250.00	2,999,550.00

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,693,542.55	1,197,017.49
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	25,193,542.55	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	25,193,542.55	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	1,197,017.49
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	1,197,017.49
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	13,328,372.71
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	13,328,372.71
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	13,328,372.71

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөг/	
					Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	44,361,947.02	99,875,691.00	359,034,913.88	00.00	503,272,551.90
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	44,361,947.02	99,875,691.00	359,034,913.88	00.00	503,272,551.90
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-24,013,591.09	00.00	-24,013,591.09
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	54,119,147.02	00.00	476,734,757.91	00.00	530,853,904.93
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	54,119,147.02	00.00	476,734,757.91	00.00	530,853,904.93
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	54,119,147.02	00.00	476,734,757.91	00.00	530,853,904.93
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	7,466,334.12	00.00	7,466,334.12
D09	2012 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	54,119,147.02	00.00	484,201,092.03	00.00	538,320,239.05

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан/ улсын төсөв/

/төгрөг/

ЭЗА	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	284,268,900.00	270,940,527.29	13,328,372.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	284,268,900.00	270,940,527.29	13,328,372.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	284,268,900.00	270,940,527.29	13,328,372.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	208,251,600.00	205,348,938.82	2,902,661.18
210101	Үндсэн цалин	167,445,300.00	146,179,190.82	21,266,109.18
210102	Нэмэгдэл	37,295,000.00	50,423,790.00	13,128,790.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	00.00	0.00
210104	Урамшуулал	3,511,300.00	8,745,958.00	-5,234,658.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,031,400.00	24,422,319.47	1,609,080.53
210201	Тэтгэврийн даатгал	17,866,900.00	17,450,432.80	416,467.20
210202	Тэтгэмжийн даатгал	2,041,100.00	2,052,992.05	-11,892.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,632,900.00	1,642,393.66	-9,493.66
210204	Ажилгүйдлийн даатгал	408,200.00	297,863.72	110,336.28
210205	Эрүүл мэндийн даатгал	4,082,300.00	2,978,637.24	1,103,662.76
2105	Норматив зардал	39,549,400.00	30,965,751.00	8,583,649.00
210502	Хоол, хүнс	39,549,400.00	30,965,751.00	8,583,649.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	592,000.00	486,466.00	105,534.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	592,000.00	486,466.00	105,534.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9844500.00	9717052.00	127,448.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,844,500.00	6,717,502.00	126,998.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,000,000.00	2,999,550.00	450.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	284,268,900.00	284,268,900.00	0.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	284,268,900.00	284,268,900.00	0.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	284,268,900.00	284,268,900.00	0.00
5	Мөнгө, гүүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	13,328,372.71	13,328,372.71
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01	01	0.00
610001	Төсвийн байгууллага	01	01	0.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	15	15	0.00
620001	Удирдах ажилтан	01	01	0.00
620002	Гүйцэтгэх ажилтан	08	08	0.00
620003	Үйлчлэх ажилтан	05	05	0.00
620004	Гэрээт ажилтан	01	01	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан/ орон нутгийн төсөв/

/төгрөг/

№	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	42,698,100.0	41,501,082.51	1,197,017.49	97.2
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	42,698,100.0	41,501,082.51	1,197,017.49	97.2
4	Бараа, үйлчилгээний зардал	42,698,100.0	41,501,082.51	1,197,017.49	97.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	15,628,000.0	15,240,695.0	387,305.0	97.5
210101	Үндсэн цалин	13,948,000.0	10,364,148.0	3,583,852.0	
210102	Нэмэгдэл	-	2,151,513.0	-2,151,513.0	-
210104	Урамшуулал	-	877,034.0	-877,034.0	-
210105	Гэрээт ажлын хөлс	1,680,000.0	1,848,000.0	-168,000.0	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шийтгэл	1,953,500.0	1,842,405.51	111,094.49	
210201	Тэтгэврийн даатгал	1,328,300.0	1,295,459.12		
210202	Тэтгэмжийн даатгал	156,300.0	152,406.95		
210203	ҮОМШӨ ний даатгал	125,200.0	121,925.58		
210204	Ажилгүйдлийн даатгал	31,200.0	24,783.06		
210205	Эрүүл мэндийн даатгал	312,500.0	247,830.80		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	24,316,600.0	23,617,982.0		
210301	Гэрэл цахилгаан	3,100,100.0	2,401,518.0		
210302	Түлш, халаалт	21,216,500.0	21,216,464.0		
2106	Эд хогшил худалдан авах	800,000.0	800,000.0		
210604	Урсгал засвар	800,000.0	800,000.0		
1310	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	42,698,100.0	41,501,082.51		
131001	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	42,698,100.0	41,501,082.51		
1310	Орон нутгийн төсвөөс	42,698,100.0	41,501,082.51		
24	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
25	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих хүүхэд бүрийн сурч хөгжих сургалтын таатай орчин бүрдүүлэн сургалтын чанар үр дүнд ахиц гаргах зорилго тавин ажиллаж байна. Ардын өв уламжлал, ёс заншил, зорилтод хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн тоглоом наадгайгаар дамжуулан бүтээлч үйлийн орчин бүрдүүлэн ард иргэдийн итгэл хүлээсэн инээж угтаж, сургуулийн өмнөх боловсролын сурагчдад эзэмшүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль - 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр
- ✓ Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"
- ✓ Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
- ✓ Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт
- ✓ Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаал "Албан томилолтын зардлын тариф" тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сагил сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сагил сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,382.2 мянган төгрөгөөр буюу 1.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	13,328.3	13,328.3
Авлага	14,000.0	0.0	-14,000.0
Бараа материал	14,338.2	29,363.4	15,025.2
Үндсэн хөрөнгө	502,599.8	495,628.4	-6,971.4
Нийт хөрөнгө	530,938.0	538,320.2	7,382.2
Өр төлбөр	84.1	0	-84.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	530,853.9	538,320.2	7,466.3
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	530,938.0	538,320.2	7,382.2

Тайлант оны эхэнд тэг төгрөг эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 13,328.3 мянган төгрөг болж өссөн нь улсын төсвийн дансны үлдэгдэл төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.

Авлага дансны эхний үлдэгдэл нь 14,000.0 мянган төгрөгийн байгууллагаас авах авлагыг 5,000.0 мянган төгрөгийн аж ахуйн материал 9,000.0 үндсэн хөрөнгө хүлээн авч барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 29,363.4 мянган төгрөг болж 15,025.2 мянган төгрөгөөр аж ахуйн материалын үлдэгдэл өссөн байна. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 495,628.4 мянган төгрөг болж 6,971.4 мянган төгрөгөөр буурсан байна. Яамны хөрөнгө оруулалт болон бусад эх үүсвэрээс бэлтгэсэн 17,082.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

Өр төлбөр данс нь 84.1 мянган төгрөгөөр буурсан нь ХХОАТ-ын өглөгийг суутган тооцсонтой холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 538,320.2 мянган төгрөг болж 7,466.31 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэнээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Сагил сумын Цэцэрлэгийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 283,164.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 283,164.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг ирүүлсэн саналаар буюу 283,164.6 мянган төгрөгөөр баталсныг төсвийн тодотгол хийгдэж 43,802.4 мянган төгрөгөөр өсгөсөн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 326,967.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 284,268.9 мянган төгрөгийг улсын төсвөөс

санхүүжүүлэхээр, 42,698.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын болон орон нутгийн төсвөөс 326,967.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 312,441.6 мянган төгрөгийг зарцуулж орон нутагт 1,197.0 мянган буцаан төвлөрүүлж, 13,328.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	284,268,900.0	270,940,527.29	13,328,372.71	95.3%
2	Орон нутгийн үндсэн үйл ажиллагааны зардал	42,698,100.0	41,501,082.0	1,197,017.0	97.1%

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 312,441.6 мянган төгрөг буюу 95.5 хувьтай байгаа нь цалин урамшууллын зардлыг 3,289.9 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 1,720.1 мянга, хүүхдийн хоолны зардлыг 8,583.6 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 232.9 мянга, гэрэл цахилгаан зардлыг 698.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тайлант онд Сагил сумын Цэцэрлэгийн нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлага гараагүй байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Сагил сумын Цэцэрлэг нь тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сагил сумын Цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Увс Финанс Аудит” ХХК-ийн аудитор Я.Тунгалаг гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал Я.Нарантуяа, чанарын хяналтыг Увс аймгийн Төрийн аудитын газрын аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Сагил сумын Цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс Финанс Аудит ХХК-нд 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 323.2 сая төгрөгөөс 1 хувиар буюу 3.2 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 335.2 сая төгрөгийн 1 хувиар буюу 3.3 сая төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Сагил сумын Цэцэрлэгийн хувьд хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд биет горим сорилыг хэрэгжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно. /АБ-4/

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс байршуулах хугацаа болоогүй 2, хугацаандаа оруулсан 148, хугацаа хоцроож 1 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

Дүн									
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дүн									
Гийг дүн									

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.БАТЦУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

УВС ФИНАНС АУДИТ ХХК-ийн АУДИТОР  Я.ТУНГАЛАГ/

2023 оны 02 дугаар сарын 06-ны өдөр